



**НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

┌ Нийслэлийн өмчийн бүртгэлээс ┐  
барилга хасаж, иргэний өмчлөлд шилжүүлэх  
тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 102/ШШ2020/02794 дүгээр шийдвэр, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 2352 дугаар магадлалын дагуу Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын баланст бүртгэлтэй, нийт 39,489,615.15 (гучин есөн сая дөрвөн зуун наян есөн мянга зургаан зуун арван таван төгрөг арван таван мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий, тус дүүргийн 10 дугаар хорооны иргэний танхимын барилгыг нийслэлийн өмчийн бүртгэлээс хасаж, Монгол Улсын иргэн Сампилын Гантогоо (РД:ЙР60120911)-ийн өмчлөлд шилжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д зөвшөөрсүгэй.

2.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 63 дугаар тогтоолоор нийслэлийн өмчийн бүртгэлээс хасаж, иргэн С.Гантогоогийн өмчлөлд шилжүүлсэн Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо, 15 дугаар хорооллын 4 дүгээр байрны 46 м.кв талбай бүхий 3 тоотын 2 өрөө орон сууцыг иргэн С.Гантогоогоос эргүүлэн авч, нийслэлийн өмчид бүртгэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (Б.Батбямба)-д даалгасугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 63 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100039